

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2021 ОНЫ 05 ДУГААР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Нэг: Аймгийн Онцгой комиссын хүрээнд: Улсын Онцгой комиссын 2008 оны 01 дүгээр сарын 16-ны хуралдаанаар баталсан Аймаг, Нийслэл, сум, дүүргийн Онцгой комиссын ажиллах журам, Монгол улсын Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Улсын нөөцийн тухай хууль тогтоомжууд, Улсын Онцгой комиссын хурлын тэмдэглэл, албан даалгавар болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон аймгийн Онцгой комиссоос 2021 оны 05 дугаар сард дараах ажлуудыг зохион байгууллаа.

Аймгийн Онцгой комисс 2021 оны тайлант 5 дугаар сард 6 удаа хуралдаж аймагт үүссэн нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай 32 асуудлыг хэлэлцэн, холбогдох асуудлаар 4 тогтоол, аймгийн Засаг даргын 3 захирамж, Онцгой комиссын даргын 4 тушаал, АОК-ын дэргэдэх шуурхай штабын 3 шийдвэр, 6 тогтоол үүрэг хүргүүлэх болон холбогдох албан бичиг, баримтыг гаргаж хэрэгжилтийг ханган ажиллав.

Улаанбаатар хот болон бусад аймгаас орон нутагт ирэх, буцах, /эрүүл мэнд буяны ажил/-тай, албан томилолт, хүнс, эм, эмнэлгийн хэрэгсэл, шатахуун, өвс тэжээл, уул уурхай, хөдөө аж ахуй, газар тариалан, зам барилга бүтээн байгуулалтын тээвэрлэлт хийх тухай хүсэлт гаргасан иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт холбогдох бичиг баримтуудыг цахимаар хүлээн авч судлан шаардлага хангасан иргэн, аж ахуйн нэгж байгууллагад Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 42 дугаар тушаалаар батлагдсан “Хот болон орон нутаг хооронд зорчих иргэдийн хөдөлгөөнийг зохицуулах түр журам”-ын дагуу нэвтрүүлэх, зөвшөөрөл олгоход онцгой анхаарч албан бичгээр ирэх зөвшөөрөл, аймгийн Онцгой комиссын тусгай зөвшөөрлөөр иргэн, тээврийн хэрэгслийг гаргаж шуурхай шийдвэрлэж ажиллав.

Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комисс, Шуурхай штабаас гарсан тогтоол, тушаал, шийдвэр, хурлын тэмдэглэлд нийцүүлэн аймгийн Засаг даргын 19 захирамж, аймгийн Онцгой комиссын 40 тогтоол, Онцгой комиссын даргын тушаал 40-ийг гарган хэрэгжилтийг хангуулан албан байгууллага, аж ахуй нэгж байгууллага иргэдэд бүх төрлийн мэдээллийн хэрэгслээр хүргэж хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. Аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар,

Цагдаагийн газар, иргэдийн төлөөлөл, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилчдын бүрэлдэхүүнтэй нийт 7 ажлын хэсэг УОК-ын даргын 41 дүгээр тушаалаар баталсан 14 үйл ажиллагааны чиглэлээр Ховд аймагт ажил үйлчилгээ явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 2021 оны 05 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, хяналт шалгалт 16 дахь өдрөө үргэлжилж байна.

Коронавируст халдвар /КОВИД-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулж аймгийн сонгуулийн хэсгийн хороодын дарга нарт Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 152 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үед коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх түр журам” -ын хэрэгжилтийг хангаж ажиллах 2 цагийн сургалтыг зохион байгууллаа.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 152 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үед коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх түр журам” -ын хэрэгжилтийг хангах зорилгоор 2021 оны 06 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулахтай холбогдуулан санал авах байранд коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх халдвар хамгааллын дэглэм сахиулах, хяналт тавих төрийн алба хаагчдыг аймгийн Онцгой комиссын даргын 2021 оны 44 дүгээр тушаалаар томилгоожуулан ажиллаж байна.

Хоёр: Нутгийн удирдлага зохион байгуулалтын хүрээнд: Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай хуулийн хүрээнд аймгийн Засаг даргад 23 өргөдөл бичгээр хүлээн авч, 17 өргөдлийг шийдвэрлэж, 6 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт 7 өргөдөл бичгээр хүлээн авч, 7 өргөдлийг шийдвэрлэж, өргөдөл гомдлын шийдвэрлэлт 80 хувьтай байна.

Угтах үйлчилгээ-Иргэдийн санал, хүсэлт, гомдол, талархал хүлээн авах 7043-1111 төв”-д 1 сувгаар 23 мэдээлэл хүлээн авахад дуудлагаар 23, гомдол 3, санал хүсэлт 16, шүүмжлэл 4 тус тус бүртгэж холбогдох хэлтэс тасгийн дарга нарт шилжүүлж, 22 иргэний санал хүсэлтэд хариу өгч, шийдвэрлэлт 95.7 хувьтай байна. Үүнд боловсролын асуудлаар 1, орчны эрүүл ахуйн асуудлаар 9, бусад асуудлаар 13 иргэн тус тус хандаж, шийдвэрлэлт 1-10 хоногтой 22, хугацаа болоогүй хүлээгдэж

байгаа гомдол 1 байна.

Иргэдээс Монгол улсын Их хурал, түүний өргөдлийн байнгын хороонд хандан гаргасан өргөдөл, санал хүсэлтийн хайрцагт ирсэн өргөдөл бүртгэгдээгүй болно.

Гурав: Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд: Орон нутгийн төсвийн байгууллагуудын 5 дугаар сард улсын төсвийн санхүүжилтээр 24148,7 сая төгрөг ирэхээс бүрэн ирж, цалин хөлс, тогтмол зардлуудыг хянаж, санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлээ. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймагт олгох орлогын шилжүүлгийн 3727.2 сая төгрөгийн санхүүжилтээс 3518.2 сая төгрөгийн санхүүжилт ирж аймаг, сумдад хуваарийн дагуу олголоо.

Сумдад санхүүгийн дэмжлэг 5710,9 сая төгрөг, аймгийн төвийн орон нутгийн төсвийн байгууллагуудад 3255,1 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт сургууль 11260,9 сая төгрөг, цэцэрлэг 5538,1 сая төгрөг, хүн эмнэлэг 2942,0 сая төгрөг, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт 196,5 сая төгрөг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 209,9 сая төгрөг тус тус олгосон.

2021 оны 1 дүгээр сарын 1-нээс 5 дугаар сарын 7-ний өдрийг хүртэл нийт 1066.9 сая төгрөгийн зардал гарсан ба 743.7 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна. Гарсан зардлын 65.8 сая төгрөгийг шатахууны зардал, 207.5 сая төгрөгийг хоолны зардалд, 69.2 сая төгрөгийг эм, эмнэлгийн хэрэгсэлд, 360.0 сая төгрөгийг оношлогооны хэрэгсэлд, 83.5 сая төгрөгийг эмнэлгийн шаардлагатай тоног төхөөрөмжид, 149.6 сая төгрөгийг тусгаарлан ажиглах байрны зардалд, 131.3 сая төгрөгийг халдвар хамгааллын холбоотой бусад зардалд тус тус зарцууллаа.

Улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээр эрүүл мэндийн салбарын цар тахлын халдварын голомтод ажилласан ажилтнуудын урамшил, тэтгэмжид 40.7 сая төгрөг, эрүүл мэндийн салбарын ажилтнуудын илүү цагийн хөлсөнд 39944.4 мянган төгрөг нийт 80644.4 мянган төгрөг, аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төвд 182.0 сая төгрөг /70 хувь буюу 127.4 сая төгрөгийг эмнэлгийн ажилтнуудын цалин хөлсөнд 30.0 хувь буюу 54.6 сая төгрөгийг эм, эмнэлгийн хэрэгсэлд зарцуулах/-ийг тус тус олголоо.

Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлсэн Засгийн газрын 43, 93 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхээр Сангийн сайдын 4 дүгээр сарын 08-ны өдрийн 56 дугаар тушаалаар орон нутгийн 2021 оны батлагдсан төсвийн санхүүгийн дэмжлэгт өөрчлөлт

орж санхүүжилт буурсан тул байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 20 хувь хэмнэх, хангамж, бараа материал, эд хогшил урсгал засварын зардал, албан томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ болон бараа үйлчилгээний зардлуудыг хэмнэлтийн горимд шилжүүлж, төсвийн байгууллагууд өөрчлөлт оруулсан шинэ хуваарийн дагуу төсвөө зориулалтаар, хэмнэлттэй зарцуулж, өр, авлага үүсгэхгүй байх бүх талын арга хэмжээ авч тогтоолын хэрэгжилтийг хангуулахаар аймгийн Засаг даргын 1/ 817 дугаар албан бичиг хүргүүлэн биелэлтэнд төрийн сан болон ажил хариуцсан албан тушаалтнууд хяналт тавин хэрэгжүүлж байна.

Санхүүгийн Зохицуулах хорооны хяналт шалгалт, зохицуулалтын газрын даргын 2021 оны 4 дүгээр сарын 08-ны 9/1314 дугаар албан бичгийн дагуу Ховд аймагт бүртгэлтэй Алтайн Ханын материал ХК-ийн үйл ажиллагаанд хяналт үзлэг хийж, дүгнэлтийг Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын 5/855 дугаар албан бичгээр хүргүүллээ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор “SMS” МТ үйлчилгээгээр төсвийн захирагч, нягтлан бодогчдод мессеж хүргүүлэн урьдчилан сануулж байна. Тайлант 5 дугаар сард Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд 1215 ширхэг зардлын ваучер бичиж, 8364,1 сая төгрөгийн зарлагын гүйлгээг гүйцэтгэлээ.

Санхүүгийн хяналт аудитын алба нь Төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Цаст-Алтай цогцолбор сургууль, Ерөнхий боловсролын 12 жилийн II сургууль, аймгийн Музей, Хөгжимт драмын театр зэрэг төсөвт байгууллагуудын 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Мөн аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний А/192 дугаар захирамжийн дагуу гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдал, хязгаарлалтын дэглэмийн үед үүрэг гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчдын хоол хүнс, шатахуун, тусгаарлах байр, хяналтын цэгүүдтэй холбоотой зардал, эм, эмнэлэгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, түргэвчилсэн тест, хамгаалах хувцас, хэрэгсэл зэрэг бараа материалын худалдан авалтын зарцуулалтанд санхүүгийн аудит хийх, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж Эрүүл мэндийн газар, Зооноз өвчин судлалын

төвийн 2021 оны 01 дүгээр сарын 01-нээс 05 дүгээр сарын 30-ны хоорондох нэмэлт дансны баримтанд санхүүгийн хяналт, шалгалтыг хийлээ.

2021 оны 05 дугаар сарын 31-ны байдлаар улс, аймаг, сум орон нутгийн төсөвт 7800,9 сая төгрөг оруулахаас 7602,6 сая төгрөг орсон нь 97,5 хувьтай байна. Үүнээс улсын төсөвт 2078,1 сая төгрөг оруулахаас 2513,4 сая төгрөг оруулсан нь 120,9 хувийн, аймгийн төсөвт 4818,7 сая төгрөг оруулахаас 4119,5 сая төгрөг оруулсан нь 85,5 хувийн, сум орон нутгийн төсөвт 904,1 сая төгрөг оруулахаас 953,6 сая төгрөг оруулсан нь 105,5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант хугацаанд бүртгэгдсэн ААНБ-уудыг аймгийн Улсын бүртгэл, статистикийн хэлтэстэй тулгалт хийж Тахаст болон Trips програмд бүртгэж, ХХК 61, Нөхөрлөл 16, төрийн бус байгууллага 10, салбар 1, хоршоо 3, нийт 90 аж ахуйн нэгж байгууллага нэмэгдлээ.

Хяналт шалгалтанд 3 татвар төлөгчийг хамруулж, татвар төлөгчийн гаалийн болон хөндлөнгийн мэдээллийг ашиглан шалгаснаар шалгалтын явцад 82,5 сая төгрөгийн зөрчилд 7,1 сая төгрөгийн нөхөн татвар ногдуулж, хуулийн дагуу 2,8 сая төгрөгийн торгууль, 0,6 сая төгрөгийн алданги тооцож, нийт 10,6 сая төгрөгийн нөхөн татвар торгууль, алданги ногдууллаа.

Дөрөв: Нийгмийн бодлого салбарын хүрээнд:

Боловсролын чиглэлээр: Монгол Улсын Засгийн газар, БШУЯ, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг удирдлага болгон Боловсролын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг сурталчлах, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, гүйцэтгэлийг дүгнэж тайлагнах, мэдээлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллалаа.

Хичээл сургалтын үйл ажиллагаанд зохиуцуулалт хийх тухай БШУСайдын А/161 дүгээр тушаалаар 05 дугаар сарын 07 өдрөөр 1-5 дугаар анги, 17- ны өдрөөр 6-11 дүгээр ангийн 2020-2021 оны хичээлийн жилийг дуусгавар болгосон. Сурагчдын зуны амралт эхэлсэнтэй холбогдуулан аливаа төрлийн байгалийн гамшиг болон бусад хүчин зүйлээс өөрсдийгөө хамгаалах, мөн хүүхдэдээ тавих хараа хяналтыг сайжруулж аюулгүй байдлыг ханган амралтыг үр дүнтэй өнгөрүүлэх талар зөвлөмжийг эцэг эх сурагчдад хүргүүлж байна.

БШУЯ, ШХА-аас хэрэгжүүлж буй “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төслийг хэрэгжүүлж буй Буянт сум, төвийн 1, 2 дугаар сургууль, Мөнххайрхан сумын ерөнхий

боловсролын нийт 4 сургуулийн хэрэгжүүлж буй жижиг төслийн хүрээнд мониторинг үйл ажиллагаа онлайнаар хийж, цахим зөвлөгөөнд нийт 25 сургууль 33 цэцэрлэгийн төлөөлөл 200 гаруй хүн оролцож санал бодлоо солилцов.

ЕБС-ийн хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор анги удирдсан багш нарыг оролцуулсан “Хамгаалагдсан ирээдүй” сургалт зохион байгуулж, сургалтад 24 суруулийн 256 анги удирдсан багш нар хамрагдлаа.

НҮБ-ын хүн амын сан БШУЯ хамтран “Анги удирдсан багшаар дамжуулан эцэг эхийн боловсролыг дэмжих” арга зүйн зөвлөмж боловсруулан аймаг бүрт 2 сургагч багш бэлтгэх сургалтанд БСУГ-ын болон Чандмань сумын сургуулийн нийгмийн ажилтан нар хамрагдан бэлтгэгдэж байна.

БШУЯ, БМДИ, Боловсролын хүрээлэнгээс зохион байгуулсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй бага ангийн багш нарын сургалтад аймгийн хэмжээнд 24 багш хамрагдаж мэргэжил дээшлүүлээ.

Элсэлтийн ерөнхий шалгалтын үр дүнг сайжруулах бэлтгэл хангах ажлын хүрээнд давтлага зохион байгуулах заавар батлах тухай БШУЯ-ны 2021 оны А/171 дүгээр тушаалын дагуу 12 дугаар ангийн сурагчид 06 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд танхимаар хичээллэж байна. Танхимаар хичээллэж буй сурагчидад 10 судлагдахуунаар нийт 17 зөвлөх багш цагийн хуваарийн дагуу судлагдахуун тус бүрээр давтлага хичээлийг цахимаар зааж, шалгуулагч нарт зориулсан судлагдахуун бүрээр цахим групп нээж тухайн группээр дамжуулан сургалт зөвлөгөөг нээлттэй мэдээлж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчдыг ЭЕШ-д амжилттай бэлтгэж дундаж оноог ахиулах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, багш нарын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын ивээл дор зохион байгуулагдаж буй “Чанартай боловсрол - Шинэ Ховдын ирээдүй” 2 сарын аян өрнүүлж амжилттай хэрэгжүүлж байна. Үүнд аймгийн хэмжээнд 2021 онд нийт 1267 төгсөгч ЭЕШ өгөхөөс өмнөх оны 281 шалгуулагч 12 дугаар анги төгсөж буй 986 шалгуулагч хамрагдаж байна. Аяны хүрээнд 2021 оны 05 дугаар сарын 22-нд аймгийн БСУГ-аас ЭЕШ-д бэлтгэж буй сурагчдад мэргэжил сурталчлах, шалгалтанд амжилттай бэлтгэхэд чиглэсэн сэтгэл зүйн зөвлөгөө өгч цахим өдөрлөг зохион байгууллаа. Өдөрлөгийн хүрээнд ХИС-ийн сургалт эрхэлсэн дэд захирал доктор Д.Өнөрнасан, БСАЗ-н тэнхимийн ахлах багш Б.Дорж, Политехник коллежийн

сургалтын менежер Б.Оюунцэцэг, нийгмийн ажилтан Ж.Баярмаа, ГБХЗХГ-ын сэтгэл зүйч С.Хишигтогтох, 3 дугаар сургуулийн сэтгэл зүйч Д.Баярмаа нар багш, сурагчдад мэдээлэл зөвлөмж өглөө. Тус өдөрлөгт 25 сургуулийн сурагч, багш нар 98 цэгээс оролцлоо.

Ковид-19 вакцины 1 дүгээр тун 25 сургууль 43 улсын болон хувийн цэцэрлэгийн 2276 багш ажилчид буюу 84% нь хамрагдсан, 2 дугаар тунд 91 хувь хамрагдаад байна. Элсэлтийн Ерөнхий шалгалтанд орж буй 18 настай 860 сурагч вакцины нэгдүгээр тунд хамрагдлаа. Төрийн өмчийн цэцэрлэг, сургуулийн хаягыг нэгдсэн стандарттай болгох хүрээнд аймгийн хэмжээнд судалгаа гаргаж судалгаанд оролцсон 33 цэцэрлэгээс 7 цэцэрлэг хангалттай, Жаргалант сумын 6, Мөнххайрхан, Мянгад, Зэрэг, Дарви, Манхан, Булган сумын 2 дугаар цэцэрлэгийн хаяг стандарт шаадлага хангасан байна.

➤ Сургууль цэцэрлэгийн удирдлагуудтай 7 хоног бүр цахим уулзалт хийж цаг үеийн болон цар тахлын нөхцөл байдалтай хэрхэн ажиллах талаар төрийн бодлого шийдвэрийг мэдээлж зөвлөгөө өгч ажиллалаа. Үүнд: Цэцэрлэгийн эрхлэгчдээс 5 настай хүүхдийг сургуульд хэрхэн бэлтгэсэн туршлага солилцох уулзалтыг 2021 оны 05 дугаар сарын 19-ны өдөр зохион байгуулж, уулзалтад төрийн өмчийн 33 цэцэрлэг оролцож, ажлын арга туршлагыг солилцов.

➤ Монгол дахь Америкт Төгсөгчдийн Холбоо (MASA), Education USA Mongolia хөтөлбөр, Лингорс, Xreading, болон АНУ-ын Элчин сайдын яам хамтран Ерөнхий боловсролын сургуулийн Англи хэлний багш нарт зориулан зохион байгуулж буй “Enrichment-II” хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагаанд аймгаас 28 багш цахимаар оролцож байна.

Эрүүл мэндийн чиглэлээр: Ховд аймагт 2021 оны 3 сарын 29-нд Ковид-19 халдварын анхны тохиолдол бүртгэгдсэн бөгөөд 2021 оны 05 дугаар сарын 27-ны байдлаар халдварын батлагдсан тохиолдол 259 бүртгэгдэж, 246 буюу 98.2 хувь нь эмчлэгдэж, одоогоор эмнэлэгт 5 хүн байгаагийн 4 нь хөнгөн, 1 хүнд хүн эмчлүүлж, ойрын хавьтлын 83, тусгаарлалтын ажиглах байранд 45 хүн байна.

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх вакцин хийх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулан ажиллуулж, тус хугацаанд 6 удаагийн татан авалтаар 54699 хүн тун вакцин татан авч 2021 оны 05 дугаар сарын 28-ны байдлаар дархлаажуулалтын 1 дүгээр тунд 42458 иргэн буюу 83.8 хувь, 2 дугаар тунд 10022

иргэн буюу 19.7 хувийг хамруулж вакцинжуулалтыг хүн амын төвлөрөл үүсгэхгүй байх, хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор 7 цэгт байршуулан мэргэжлийн 7 баг ажиллуулан гүйцэтгэж байна.

Халдварт өвчин ялангуяа ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр 5 дугаар сард Ховд телевиз болон гэрээт сайтуудаар дамжуулан “Маскаа зүүж, гараа халдваргүйжүүлье”, “Дархлаажуулалтад бүрэн хамрагдай”, “Хамтдаа хэрэгжүүлье”, “Маскаа тогтмол зүүж хэвшье” зэрэг 5 төрлийн шторк, вакцинд хамруулахад чиглэсэн төрлийн инфографикийг гэрээт сайтууд, орон нутгийн ТВ-үүдээр үечлэлтэйгээр сурталчлах арга хэмжээг авлаа.

Коронавируст халдварын батлагдсан тохиолдолд түүний хавьталыг бүртгэх, шинжилгээ, тандалтын процессыг автомажуулах зорилгоор 1.4 сая төгрөгөөр “Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 1 пос машин олголоо.

Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж “Тэмбүүг устгая” зорилтын хүрээнд ХДХВ халдвар илрүүлэх шинжилгээнд 5268, тэмбүүгийн халдвар илрүүлэх шинжилгээнд 5278 хүн хамрагдсанаас 36 тэмбүүгийн халдвартай хүн шинээр оношлон эмчилгээнд хамруулаад байна.

Эрсдэлт бүлгийн эхчүүдийн жирэмслэлтээс хамгаалах аргын хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төв зэрэг 23 байгууллагуудад 6 нэр төрлийн 5044 ширхэг жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийг хуваарилан олголоо. Мөн жирэмсэн болон хөхүүл эхэд хэрэглэх 5.8 сая төгрөгийн үнэ бүхий олон найрлагат бичил тэжээл, хүүхдүүдэд Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс хуваарилагдан ирсэн өндөр тунт А витаминьг сумдад хуваариараар олгов.

Тайлант оны эхний 4 сарын байдлаар нийт үзлэг 124656 бүртгэгдснээс урьдчилан сэргийлэх үзлэг 32798 буюу нийт үзлэгээс 26.3 хувийг эзэлж байна. Нийт төрөлт 666 бүртгэгдсэн ба өнгөрсөн оны үеэс 66 тохиолдлоор буурч, нялхсын эндэгдэл 8 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөнд 11.9 промилль буюу өмнөх оны мөн энэ үеэс 0.4 промилээр, 0-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл 10 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөнд 14.8 промилль буюу өмнөх оны мөн энэ үеэс 0.2 промилоор тус тус буурсан ба эхийн эндэгдэл 1 тохиолдол бүртгэгдлээ.

Тайлант 5 дугаар сард халдварт өвчний 335 тохиолдол бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үеэс 97 тохиолдлоор өссөний 70.7 хувийг коронавируст халдвар, 20.2 хувийг бэлгийн замаар дамжих өвчин, 3.5 хувийг арьсны мөөгөнцөртөх өвчин тус тус эзэлж, осол гэмтлийн өвчлөл 107, осол гэмтлийн нас баралт 15 бүртгэгдлээ.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Зооноз өвчин судлалын төв, Булган, Буянт өрхийн эрүүл мэндийн төв, БОЭТ-ийн дагалдах барилгууд, Мянгад сумын эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгуудыг Сангийн яамны хөрөнгө оруулалтын нэгдсэн программд шивж 2022 онд шинээр барих, өргөтгөлийн барилгын төслийн жагсаалтанд хамрууллаа.

Тав: Сумдын мэдээлэл:

Жаргалант сум: Сумын нутаг дэвсгэрээс гарч байгаа 20 тээврийн хэрэгсэл, бараа материалд нийт 6200 м² талбайд ариутгал хийлээ. Жаргалант сумын газар тариалангийн бүсэд ажил эрхлэгч тариаланчдад төвөөс гарч орох түр үнэмлэх 100 ширхэгийг олгосон.

Аймгийн хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан зарим үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааны цагийн хуваарьт өөрчлөлт орж халдвар, хамгааллын дэглэм сахиулах ажлыг эрчимжүүлэх чиглэл өгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллалаанд харьяа багийн Засаг дарга, Нийгмийн ажилтнууд хамтран хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн ИТХ, Дэлнхийн зөн ОУБ-ын ОНХ-тэй хамтран хэрэгжүүлж буй “Хүүхдэд ээлтэй Ховд” аяны хүрээнд “Хамгаалагдсан ирээдүй” хүүхэд хамгааллын хамтарсан багийн чадавхижуулах сургалтанд нийгмийн бодлогын орлогч дарга, мэргэжилтэн, багийн засаг дарга, нийгмийн ажилтан, хэсгийн цагдаа, сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, ӨЭМТ-ийн эмч нар хамрагдлаа.

Амьжиргааны түвшинд хамрагдаагүй болон хүнсний эрхийн бичгэнд хамрагдаж чадаагүй иргэдийн судалгаа, Өрх толгойлсон эцэг эхчүүдийн судалгаа, сургууль, цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдүүдийн судалгааг шинэчлэн аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэст хүргүүлэв.

Жаргалант суманд үйл ажиллагаа явуулдаг эмийн сангуудаар Витамин С, Д, бусад халууны эм худалдан авч үйлчлүүлсэн иргэдийн судалгааг өдөр бүр авч аймгийн ОБГ-ын шуурхай штабт хүргүүлж байна.

Аймгийн мал эмнэлгийн газрын даргын 2021 оны А/43 дугаар тушаалын дагуу сумын Мал эмнэлгийн тасагтай хамтран 100 хуц, 50 ухна ээмэгжүүлэх ажлыг зохион байгууллаа.

Буянт багийн 15-26 тоотод оршин суух иргэн Ч.Ихэрзоригийн адууны биеэр гүвдрүүт тууралт гарч, хамар битүүрсэн гэсэн анемназтай дуудлага хүлээн авч тасгийн байцаагч эмнэлзүйн үзлэг хийж, адууны нийлүүлэг болон ямлуурын харшил сорил тавьж аймгийн лабораторид цусны дээж авч хүргүүлэн хариу хүлээж байна.

Сумын Засаг даргын 2021 оны А/136 дугаар захирамийн дагуу Улаанбаатар хотоос тээвэрлэгдэн ирсэн хүнсний бүтээгдэхүүн, бараа, материалыг Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын /хуучин/ байрны хашаанд аймгийн Онцгой комиссын шуурхай штабаас баталсан маршрутын дагуу 17-22 цагийн хооронд нийт 33 тээврийн хэрэгслийн 9400м² талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийж байна.

Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх арга хэмжээг зохион байгуулах тухай Мал эмнэлгийн газрын даргын А/28 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж МЭҮН-үүдэд аймгийн Онцгой байдлын газраас зөвшөөрөл авч Хүрэн хошуу, Харзны эх үйлчилгээний нэгжүүдийг ДХХ, Боом, Сахуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд гаргаж ДХХ вакцин 580,581 кодтой 70л, Боом вакцин 658 кодтой 6,4л, Сахуу вакцин 569 кодтой 25л мөн жижиг хөргүүр 2 ширхэг хүлээн авч МЭҮН-ийн эмч нарт хүлээлгэн өглөө.

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигийн дагуу бүх нийтээр мод тарих өдрөөр хайлаас 3700, улиас 50, бургас 500, шинэс 150, нарс 100, монос 100, буйлс 67 нийт 4667 ширхэг мод бут тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн. Ховд хотын төвийн нийтийн эзэмшлийн талбайд 260 ширхэг мандал, сад бүхий 19213,76м² ногоон байгууламж байдаг, сумын Засаг даргын 2021 оны А/116 дугаар захирамжаар Ховд хотод үйл ажиллагаа явуулж буй 75 төрийн байгууллагад 13384.84м², Хот тохижуулах газарт 1193.38м², хувийн хэвшлийн 27 аж ахуйн нэгжид 3007.54м² тус тус талбайг хариуцан цэцэгжүүлэхээр гэрээ байгууллаа.

Ховд хотын төвөөс мал болон туслах аж ахуйг гаргах тухай сумын Засаг даргын 2021 оны А/93 дугаар захирамжийн дагуу хотын төвд мал тэжээж буй 122 өрхөд санамж, мэдэгдэл хүргүүлж журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг зөвлөв.

Сумын хэмжээнд ус ашиглагч иргэн аж ахуйн нэгж байгууллагууд нь усны тухай хуулийн 26 дугаар зүйлд зааснаар тодорхой зориулалт, хугацаа, гэрээ зөвшөөрлийн

үндсэн дээр хуулийн дагуу ус ашиглах эрхтэй байдаг. Усны тухай хууль холбогдох дүрэм журмын хэрэгжилтийг хангаж БОАЖГ,МХГ, ХНХГСГЗ, Жаргалант сумын ЗДТГ-ын хамтран ус ашиглагч иргэн аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж зөвшөөрөлгүй худаг гаргах үйл ажиллагааг таслан зогсоов.

Ховд хотын авто болон явган замын гэмтэл, гарц, тэмдэг тэмдэглэгээ, хайс, саад хашлага, самбарын гэмтэл, эвдэрсэн байшин барилга, гудамж талбай, эвдэрсэн ажлын тоо хэмжээ гаргах ажлын хэсгийг сумын Засаг даргын захирамжаар байгуулан засвар үйлчилгээ шаардлагатай байгаа ажлыг зургаар баталгаажуулан гаргаж, ажлын үр дүнг нэгтгэн аймгийн удирдлага, ХБХ-т хүргүүлж хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх санал тавьсаны үр дүнд зарим ажлын гэрээ хийгдэж ажлын гүйцэтгэл эхлээд байна.

Сумын 2021 оны ОНХС-ийн хөрөнгө оруулалтанд тусгагдсан зах орчмын тохижилт, буянт голын гүүр, бохир усны таг зэрэг ажлуудын техникийн даалгавар гаргаж, гэрээ байгууллаа. Хотын захирагчийн ажлын албанаас хотын гэрэлтүүлгийн судалгааг нарийвчлан гаргаж асахгүй байгаа 360 гэрлийг асаах арга хэмжээ авч байна. Нийт 150 гэрэл шинээр авч, нөхөх боломжтой 50 гэрэл, дутагдах 160 гэрлийг захиалахаар төлөвлөлөө.

Жаргалант сумын хэмжээнд гэр хороололд 5200 гаруй, хөдөө орон нутгийн айл өрхүүд нийлээд 7000 гаруй өрх айл байна. Сумаас 12 багаараа дамжуулан асуумж судалгаа гаргахад нийт өрхийн 50 орчим хувь нь аргал, мод, нүүрсний хомсдолд орж байгаа судалгаа гарсан тул түлшний мод, аргалын худалдаа борлуулалт хийдэг иргэдэд тусгай зөвшөөрөл олгуулж гэр хорооллын айл өрх, гудамж талбайн хэсгээр явуулын борлуулалт хийсний үр дүнд иргэдийн түлшний хэрэгцээг зохих түвшинд хангууллаа.

Эрдэнэбүрэн сум: Сумын хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэхэд анхаарч Эрүүл мэндийн яамнаас Эрүүл мэндийн төвд "УАЗ ФУРГОН" маркийн авто машин шийдвэрлэж өгсөн.

Ковид-19 вакцины 2 дугаар ээлжийн 111 тунг хүлээн авч, сумын бүх төрийн албан хаагч, үйлчилгээ явуулдаг аж ахуй нэгжүүд, банкны ажилчид, суурин баг буюу Хар ус багт ажиллаж, амьдарч байгаа 65-аас дээш настай ахмадуудыг нэгдүгээр тунд хамруулж байна.

Татвар төлөгчдийн өдрийн хүрээнд Эрдэнэбүрэн сум нь 2020 оны "Шилдэг татвар төлөгч"-өөр шалгарсан Хүрэн товгор ББН, болон гар зургийн уралдаанд

оролцсон ирээдүйн татвар төлөгч сурагч нараа шалгаруулан өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.

Мод тарих үндэсний өдрийг тохиолдуулан Нутгийн удирдлагын ордны хашаанд 300ш гоёлын мод, сүмийн хашаанд 200ш улиас тарьж ногоон байгууламжийн тоог нэмэгдүүллээ.

Ховд голын Нарийн усны шар ширэгний зам засварын ажлыг аймгийн ОНХСангийн 15 сая төгрөгийн санхүүжилттэйгээр ВВZone ХХК хийж гүйцэтгэн ашиглалтанд хүлээн аваад байна. ОНХС-ын 10 сая төгрөгийн санхүүжилтээр сумын хогийн нэгдсэн цэгийг 2 хово, 1 ковш машин техник ашиглан 20*40*2метр харьцаатай нүх ухуулж хогийг түрж цэгцэллээ. Мөн сумын төвийн 3 газрын балгас, хогийг түрж газрыг тэгшлэн цэвэрлэв.

Сумын онцгой комиссын шийдвэрийн дагуу танхимаар давтлага өгөх 12 дугаар ангийн сурагчдад элсэлтийн ерөнхий шалгалтанд бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө гарган хорио цээрийн дэглэмийн дагуу сурагч багш бүрийн халуун хэмжих, гар ариутгах, тусгайлан анги танхим бэлтгэн, сурагч багш бүр маскаа зүүж хичээл сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Ховд Их сургуулийн нэрэмжит Баруун бүсийн орос хэлний онлайн олимпиадад сумын ЕБС-ийн 12а ангийн сурагч М.Бадамханд 3 дугаар байр, 12а ангийн сурагч А.Амин-Эрдэнэ 5 дугаар эзэлж амжилттай оролцлоо.

Цэцэг сум: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах”, Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө оруулалтаар “Соёлын төвд үзэгчдийн сандал худалдан авах”, “Хөшөөт багт цэцэрлэгт хүрээлэн байгуулах”, “Хавцгайн амны усыг Зүүн хоолойруу татах”, “Хяналтын камержуулалт” зэрэг ажлуудын тендер худалдан авалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу tender.gov.mn цахим системээр дамжуулан нээлттэй зарлаж, давсан орлогоор “ЗДТГ-т Приус машин худалдан авах” тендер зарлагдаад байна.

Аймгийн ИТХ-ын ажлын албанаас зарласан “Хог биш мод тарья” аянд сумын ИТХ, ЗДТГ, МоЭнКо БОТХТасаг хамтран нэгдэж агаар орчны бохирдол болон цөлжилтийг сааруулах, сумын тохижилт, хог хаягдлыг бууруулах ногоон байгууламжийг иргэд олон нийтийн оролцоотойгоор нэмэгдүүлэх, иргэдийн ая тухтай орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч аж ахуйн нэгж, албан

байгууллагуудыг хамруулан өргөн цар хүрээтэй ажил зохион байгуулж, 258 иргэн гар бие оролцож Чацаргана, Улиас, Хайлаас,, Бургас, зэрэг 4 н төрлийн 2200 гаруй мод, бут сөөгийг тарьж, хашиж хамгаалах, ургуулах ажил хийгдэж байна.

“Чанартай боловсрол – Шинэ Ховдын ирээдүй” аяны удирдамжийн дагуу төгсөх ангийн 9, 12 дугаар ангийн сурагчид мэргэжил сонголтын сургалтанд үе шаттайгаар хамрагдаж байна. ЭЕШ-ийн хичээл тус бүрийн ээлжит сорилууд зохион байгуулагдаж, холбогдох албан тушаалтнуудад энэ талаар тухай мэдээлэв. :

Мянган угалзат байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагчид цогцолборт газрын орчны болон хязгаарлалтын бүсэд хамтарсан болон ганцаарчилсан 15 удаагийн хяналт шалгалтаар бүсийн Баянгол, Ар булаг, Тал булаг, Хөшөөт, Их бэлчир, Барлаг, Хиагт, Дайргат, Бодонч, Сүлжээт, Бөөрөг, Номт, Хужирт, Нүцгэн, Агуйт, Шанд, Буга боодог, Хөх Хөндий газруудад ажиллав.

Баянгол багийн Засаг даргын /БЦГ-ын хязгаарлалтын бүс нутаг Баянголд улсын дугааргүй Ланд-80 маркийн авто машинтай сэжиг бүхий хүмүүс металл хайгч тавиад явж байна гэсэн/ мэдээллийн дагуу Хамгаалалтын захиргааны хуулийн хэрэгжилт, хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн, байгаль хамгаалагч, сумын хэсгийн төлөөлөгч, жолооч нар 2021 оны 05 дугаар сарын 03-ны орой 22:00 цагийн үед тус газарт эргүүл, хяналт шалгалтаар ажиллахад хяналтын явцад тухайн хүмүүс зугтсан байсан. 5 дугаар сарын 8-нд дахин Ланд-80 авто машинтай хүмүүс ирсэн байна гэх тухайн хэсгийг хариуцсан байгаль хамгаалагчийн мэдээллийн дагуу хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагч, сумын хэсгийн төлөөлөгч, цагдаа жолооч нар очиход өмнө ирж байсан улсын дугааргүй Ланд-80-тай хүмүүс дахин металл хайгч тавьж байгаад баригдалгүй зугтсан 140 гаруй км хөөгөөд барьж чадаагүй болно. Хамгаалалтын захиргааны зүгээс тус газарт байнгын эргүүл пост, хяналт тавин ажиллаж байна.

Мөн Хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагчид цогцолборт газрын орчны болон хязгаарлалтын бүсийн Хиагтын гол, Бөөргийн нуур, Бодонч гол, Баянхүрээ, Сүлжээт, Ногоон нуур, Дайргат, Балгатай, Ар булаг, Хөх Хөндий, Нарийн салаа, Хар ам, Зааг, Тэмээт зэрэг газруудаар ажиглалт судалгаа хийж, ажиглалт судалгаагаар 14 сүргийн 370 аргаль хонь, 8 сүргийн 120 янгир ямаа 2 сүргийн 25 халиун буга, 22 алтайн хойлог тэмдэглэж бүртгэлжүүлэв. Байгаль хамгаалагчид

хариуцсан бүс нутагтаа уст цэгийн тооллого судалгаа, суурин болон нүүдлийн шувуудын зүйл, тархацын судалгаа хийж байна.

Тайлант сард Мянган угалзатын нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанаас бүс нутгийн 8 өрхийн 43 иргэнд хамгаалалтын захиргааны үйл ажиллагаа, ажлын явц, үр дүнгийн талаар сурталчлан мэдээлж, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд 14 хоногийн хугацаатай “Байгаль, түүх соёлын өв уламжлалт” шүлгийн уралдаан зарлаж шагналт байранд орсон сурагчдыг шагнаж урамшуулан ажиллалаа.

Мөст сум: Ковид-19 халдварт өвчинтэй тэмцэх Улс, аймгийн онцгой комисс, аймаг, сумын Засаг дарга захирамжийн дагуу өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг буурсантай холбоотой сумын онцгой комисс ажиллах хуваарь гарган иргэдэд заавар зөвлөмж өгч хяналт тавин ажиллаж байна. Сумын гудамж талбай, аж ахуйн нэгж, албан байгууллагын орчинд ариутгал халдваргүйтгэлийг Эрүүл мэндийн төвөөс хийсэн, вакцинд 1318 иргэн буюу нийт иргэдийн 90% хамрагдаад байна.

Сумын Иргэний бүртгэлийн ажилтан шинээр төрсөн 4 хүүхэд бүртгэж, иргэний үнэмлэх захиалга 5 иргэнээс авч, 4 иргэний үл хөдлөх хөрөнгийг бүртгэж нийт 10 өргөдөл гомдол хугацаанд нь шийдвэрлэв.

Нийгмийн даатгалын сангаас 1995 оноос өмнөх тэтгэвэр авагч 52 өндөр настанд 18,281,394 төгрөг 1995 оноос хойшхи 341 өндөр настанд 171,117,940 төгрөг, цэргийн тэтгэвэр авагч 2 иргэнд 1,076,396 төгрөг, тахир дутуугын тэтгэвэр авагч 44 иргэнд 14,373,640 төгрөг, тэжээгчээ алдасны тэтгэвэр авагч 22 иргэнд 7,144,508 төгрөгийг тус тус олголоо.

Эрүүл мэндийн даатгалд 37 даатгуулагчийн 1,562,400 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлээр 5 байгууллагын 36,572,600 мянган төгрөг, нийт 38135.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлэв. Сангаас 3 төрлийн тэтгэвэрт 2 арилжааны банкаар 171,057,940 мянган төгрөг, 2 төрлийн тэтгэмжинд 2017.8 мянган төгрөг, нийт 148866.4 мянган төгрөг тавьж олгосон ба тайлант сард шинээр тэтгэвэрт 8 иргэн, сунгалт хөдөлгөөнийг 5 тэтгэвэр авагч хийлгэв.

Халамжийн ажилтан Цалинтай 4 ээж, жирэмсэн ээж 5 иргэн, шинэ төрсөн 3 хүүхэд бүртгэв. АДЗ хурал 2 удаа хуралдаж, нийтийг хамарсан малжуулах ажлын байрыг дэмжих төсөл хөлбөрүүдийг хэлэлцэж, төслийн эргэн төлөлтөөр 18 сая төгрөгийг татан төвлөрүүллээ.

Тайлант сард 65 аж ахуй нэгжийн 1 улирлын тайлан хүлээн авч журмын дагуу авто техникийн үзлэгт 280 гаруй тээврийн хэрэгсэл хамрагдлаа. Татвар төлөгчдийн өдрийг тохиолдуулан татвар төлөгч цахим уралдаанд 2 иргэн аж ахуйн нэгж оролцож шилдэг татвар төлөгч аж ахуйн нэгжээр “Хос өнхөрүүш”- ХХХК шалгарлаа.

Мал эмнэлэгийн Ерөнхий газар, аймгийн Мал эмнэлэгийн газраас өгсөн үүрэг даалгавар заавар зөвлөмжийг мөрдлөг болгон гарал үүслийн гэрчилгээгээр Адуу-7, Үхэр-12, Хонь-361, Ямаа-2, Хонины мах-101кг-г цахимаар бичиж баталгаажуулалт хийв. Сумын МЭТ-ийн ажлын хэсэг 2021 оны 05 дугаар сарын 13, 14 өдрүүдэд шүлхий өвчний тандах шинжилгээнд сонгогдсон 4 өрх айлын 48 бог, 16 үхрээс цусны дээж авч, цусны ийлдсийг ялгаж аймгийн лабораторид тайлангийн хамт тушаалаа.

Аймгийн мал эмнэлгийн газраас Боом, Сахуу ДХХ, Дуут хавдар зэрэг өвчнүүдийн вакцин болон туулгалт, ариутгалын бодисыг тээвэрлэн авчирч, МЭҮН-үүдэд хуваарийн дагуу олгож төлөвлөгөөт тарилга туулгалт, вакцинжуулалтын ажлыг эхлүүлээд байна.

Ажлын төлөлөгөөний дагуу төл бойжилт хорогдлын мэдээ, халдваргүйтгэлийн мэдээ, Отор нүүдэл малын шилжилт хэдөлгөөний мэдээ, Сүргийн эрүүл мэндийн үзлэгийн мэдээ, ариутгал халдваргүйтгэлийн мэдээ, сэг зэм устгалын мэдээ, төлөвлөгөөт вакцины гүйцэтгэлийн мэдээ, хяналт шалгалтын мэдээ тус бүрийг тухай бүр хугацаанд нь аймгийн МЭГ-т хүргүүлэн ажиллаж байна.

Сумын Ерөнхий боловсролын сургууль нь БШУСайдын А/171 дугаар “Давтлага зохион байгуулах заавар батлах тухай тушаалын дагуу 5-р сарын 17-ны өдрөөс эхлэн 1 сарын хугацаатай ЭЕШ-ын давтлагыг танхимаар зохион байгуулахаар төлөвлөн сурагч, багш, ажилчид халдвар хамгааллын дэглэмээ баримтлан хичээллэж байна, Багш, ажилчид вакцины II тун, 18 нас хүрсэн нийт 30 хүүхдээс 27 хүүхэд вакцины эхний тунд хамрагдлаа.

Аймгийн Засаг даргын ивээл доор зохион байгуулагдаж буй “Чанартай боловсрол-Шинэ Ховдын ирээдүй” аян 5-р сарын 1-ээс 7-р сарын 1-ний хугацаанд хэрэгжихээр болж аяны хэрэгжилтийн хүрээнд сурагчдын элсэлтийн шалгалтын үр дүнг дээшлүүлэх, бэлтгэлийг сайжруулахад анхаарч мэргэжил арга зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх зөвлөх багш ажиллуулж, сурагчид 7 хоногт 1 удаа зөвлөх багшийн хичээлд сууж байна.

Сумын Эрүүл мэндийн төв нь урьдчилан сэргийлэх үзлэгт 1228 иргэн хамрагдаж 28 удаагийн дуудлагад явж, 16 иргэнийг гэрийн идэвхтэй эргэлтээр үзэж, 28 иргэн хэвтэн эмчлүүлж нийт 1426 иргэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг шуурхай хүргэж ажиллалаа. Цусны шинжилгээнд 87, шээсний шинжилгээнд 79, Ковидын шинжилгээнд 15 иргэн хамрагдлаа. Ковид -19 вакцины 1 дүгээр тунд 1284 иргэн, 2 дугаар тунд 112 иргэн хамрагдав.

Мөнххайрхан сум: Сумын Засаг даргын Тамгын газрын хурал 2 удаа, Онцгой комиссын хурал 1 удаа, албан байгууллагын дарга, эрхлэгч нарын хурал 1 удаа тус тус хуралдаж, цаг үеийн ажлын талаар хэлэлцэн, 5 дугаар сард хийх ажлын талаар үүрэг чиглэл өглөө.

Сумын удирдлагууд 2 удаа цахим хуралд оролцож, аймгийн Засаг дарга, аймгийн Онцгой комиссоос өгсөн үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Сумын Засаг даргын Тамгын газарт нийт 18 бичиг хүлээн авч хугацаатай 4 бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлж 2 өргөдөл хүлээн авч, 3 иргэнд архивын лавлагаа магадлагаа олгож сумын Засаг даргын нийтээр дагаж мөрдөгдөх 6 захирамжийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Сумы Сонгуулийн хорооны 5 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар Хэсгийн хороодыг байгуулж, хэсгийн хорооны бүрэлдэхүүнд сургалтанд оролцож гэрчилгээ авсан нийт 30 төрийн албан хаагчийг томилон ажиллуулж байна.

Хүүхэд хамгааллын хамтарсан багийн сургалтыг аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын газраас цахим сургалт зохион байгуулж, 2021 оны 05 дугаар сарын 03-04-ны өдрүүдэд хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, кейс дээр ажиллах, хууль эрх зүйн орчин, сайн туршлагын талаар мэдээлэл солилцлоо.

Иргэний танхимд 5 удаагийн цахим уулзалт, хурал, сургалт зохион байгуулагдлаа. Сумын ИТХ-ын Төлөөлөгчдийн “Манлайлал-Бодлогын шинжилгээ” “Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага-Эрх зүйн орчин, Төлөөлөгчийн бүрэн эрх” сэдвүүдээр аймгийн ИТХурлаас 2 өдөр, МАН-аас 2 өдрийн сургалт зохион байгуулав. Аймгийн сонгуулийн хорооны сургалт 05 дугаар сарын 12-ны өдөр иргэний танхимд 4 хэсгийн хорооноос 4 төлөөллийг оролцуулан зохион байгуулав.

Санхүүгийн алба нь төсөвт байгууллагуудын 5 дугаар сарын санхүүжилтийн эрх нээх, гүйлгээг хянан баталгаажуулах өглөг, авлагын мэдээг хүлээн авч Сангийн

яамны удирдлагын мэдээллийн системд шивж орууллаа. Шилэн дансны вэйб сайтад төсвийн төвлөрүлэн захирагчийн сар бүр оруулах 5, тухай бүр оруулах 6 мэдээллийг шивж байршууллаа.

Санхүүгийн дэмжлэг 5 дугаар сарын хуваарийн дагуу 37037300 төгрөг ирснийг төсөвт байгууллагуудад хувиарын дагуу сумын ИТХ-д 4041300 төгрөг, ЗДТГ-т 26330900 төгрөг, Соёлын төвд 6042900 төгрөг, ерөнхий боловсролын сургуульд 485400 төгрөг, Хүүхдийн цэцэрлэгт 197000 төгрөг, Эрүүл мэндийн төвд 259000 төгрөг тус тус олголоо.

Аймгийн 2020 оны санхүүгийн нэгдсэн тайлан мөн Төсвийн шууд захирагчдын 2020 оны санхүүгийн тайлан гарч төрийн аудит хийгдэж байгаатай холбогдуулан Сангийн яамны “Э-тайлан” цахим системд байнга нэвтэрч төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нартай тоон мэдээллүүдийг хянан үзэж аудитын байгууллагын болон аймгийн ерөнхий нягтлан бодогчид тайлбар өгч байнгын холбоотой ажиллалаа.

Орлогын нэр төрлийн мэдээг гаргаж албажуулан аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн орлогын мэргэжилтэнд цаасаар болон цахимаар илгээлээ.

Байгууллагын 19 зардлын ваучер импортлож өгөгдлийг дамжуулан, нийт мөнгөн дүнгээр 82750,0 мянган төгрөгийн гүйлгээг анхан шатны баримт болон бусад баримтыг үндэслэн шивсэн.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөр 11732.5 мянган төгрөгийн орлогыг түүвэрлэн гаргаж хасалтын бүртгэл хөтөлж, Сум хөгжүүлэх сангийн зээлийн гэрээний хугацаа дууссан, графикт хугацаа хэтэрсэн зээлдэгч нараас 16 зээлдэгч эргэн төлөлтийг хийлгэв. Үндсэн зээл-16.258.000 төгрөг, хүү-586.327 төгрөг, алданги-297,216 төгрөг нийт 17.141.543 төгрөгийн эргэн төлөлтийг сум хөгжүүлэх сангийн 100161155401 дансанд төвлөрүүлэв.

Аймгийн Онцгой комиссын 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 27 дугаар тогтоолын дагуу ХХААГ-аас баталсан хүнс, болон малын тэжээл, өргөн хэрэглээний барааны бүтээгдэхүүн тээвэрлэх хуваарийн дугаа 3 удаа 6 тээврийн хэрэгсэлээр татан авалт хийж Мал эмнэлэгийн тасагтай хамтран ариутгал халдваргүйжүүлэлт хийж ажиллалаа Мөн Короновируст халдвар /Ковид-19/ цар тахлын тархалтай холбогдуулан халдвар хамгаалалын дэглэм баримтлах, иргэдэд тогтмол бээлий масктай үйлчлэх спиртэн суурьтай гар ариутгагчийг дэлгүүрүүдэд тогтмол

хэрэглэхийг зөвлөлөө. Хүнснийн гол нэрийн бараа бүтээгдэхүүний нөөцийн болон үнийн судалгааг 1 дэх, 4 дэх өдөр тогтмол ХХААГ-т хүргүүлж байна.

Төл бойжилт, том малын зүй бус хорогдлын мэдээг хүснэгтээр үзүүлэхэд:

№	Багийн нэр	Ингэ	Гүү	Үнээ	Хонь	Ямаа	Бүгд
Төллөвөл зохих	Алаг	9	434	864	6255	7806	15368
	Борт	4	335	1309	6442	5030	13120
	Хаг	-	254	869	4430	2957	8510
	Сэнхэр	1	237	500	4988	5194	10920
	Дүн	14	1260	3542	22115	20987	47918
Төллөсөн	Алаг	3	217	560	5754	7415	13949
	Борт	1	35	809	5926	4778	11559
	Хаг	-	128	563	4075	2650	7416
	Сэнхэр	-	130	301	4588	4830	9849
	Дүн	4	510	2233	20343	19683	42773
Хорогдсон	Алаг	-	17	56	282	384	739
	Борт	-	5	14	131	250	400
	Хаг	-	13	15	75	62	165
	Сэнхэр	-	13	8	50	73	174
	Дүн	-	48	93	538	769	1478
Бойжсон	Алаг	3	200	504	5472	7031	13210
	Борт	1	30	795	5795	4538	11159
	Хаг	-	115	548	4000	2588	7251
	Сэнхэр	-	117	293	4538	4757	9675
	Дүн	4	462	2140	19805	18914	41295

Том малын зүй бус хорогдол

№	Багийн нэр	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Бүгд
Том малын	Алаг	-	10	30	80	100	220
	Борт		11	49	36	23	127
	Хаг		8	20	55	25	113

	Сэнхэр		13	30	45	30	148
	Дүн		42	129	216	146	608

Нийт 47918 толгой мал төллөхөөс 42773 толгой мал төллөж мал төллөлт 89,2 хувьтай, төл бойжилт 97,2 хувьтай байна. Тайлант сард 2020 онд үндэсний үйлдвэрт хонь тэмээний ноос тушаасан 194 малчин мал бүхий өрхийн 31.8 тн ноос тушаасан баримт бүртгэгдэж 132 малчин мал бүхий өрхөд 32.670.000 төгрөгийн урамшуулал олгодсон. Мөнхийн дулаан гэр ХХК-д ноос тушаасан 52 өрхийн 7.6 тн ноосны урамшуулал ороогүй шалтгаан нь 10 өрхийн банкны данс, нэр зөрүүтэй байсныг засварлаж илгээлээ.

Ерөнхий боловсролын сургуулийн багш нар хичээлийн агуулгын хоцрогдолын судалгааг анги, хичээл тус бүрээр гаргаж танхимын сургалтын хоцрогдол арилгах төлөвлөгөө гарган ажиллаж байна. Сурагчдын дүн мэдээллийг мэдээллийн цахим системд оруулж төгсөлт, анги дэвшилтийн үйл ажиллагааг зохион байгуулсан. Анги даасан багш нар хувийн хэргийн бичилт хийж, цахим журнал хөтөлж хаалт хийв.

ЭЕШ-ийн давтлагыг 7 хоногт багш бүр 10 цагийн давтлага өгч, сорилго шалгалтыг сургуулиас хичээл тус бүрээр 2, нийт 16 удаа, БСУГ-тай хамтран долоо хоногт хичээл тус бүрд 2-3, нийт 66 удаагийн сорилгод сурагчдыг хамруулж анализ дүгнэлт хийн ажиллаж байна.

Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр-5 төслийн хүрээнд агуулгын хоцрогдол арилгахад мэдээллийн технологийг ашиглах давуу тал сэдвээр төсөл бичиж БСШУЯ-д хүргүүлээ. Мөн сургуулийн ажилчид Тогтвортой хөгжлийн боловсрол -2 төслийн хүрээнд “судалъя, суралцъя, шинжилье” төслийг хэрэгжүүлж хүлэмж, гэрийн буурь засах, ногооны талбай бэлдэх ажлыг хийж гүйцэтгэлээ. Багш ажилчдыг ковид-19 вакцины 2 дахь тунд 34 хүнийг хамрууллаа.

Хүүхдийн цэцэрлэгийн багш нар чиглэл чиглэлээр хүүхдийг цахим хичээлд хамруулах интерактив хичээл, зөвлөмж, шторк бэлдэж групп чатад байршуулж, цахим хичээлд хамрагдах боломжгүй хүүхдүүдэд цаасан хэлбэрээр даалгавар хүргүүлж хянан гүйцэтгүүлж байна.

Багш ажилчид хариуцлагатай жижүүр, эргүүл, пост бүх нийтийн ажилд томилогдон байгууллагын дотно гаднах тохижилтод анхаарч туршилтын талбай

бэлдэх, цэцгийн мандал шинээр хийх, ногоо тарих, анги танхимд засвар цэвэрлэгээ ариутгал халдваргүйтгэл хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэв.

Сумын цахим хуудсаар КОВИД-19 халдвар, дархлаажуулалттай холбоотой мэдээ мэдээллийг цаг тухайн бүрт нь байршуулж иргэдэд нээлттэй мэдээлж ажилласан. Умайн хүзүү хөхний өмөнгийн хавдрын эрт илрүүлэг шинжилгээнд 12, эсийн шинжилгээнд 7 зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийг хамруулж оношлов. Клиник шинжилгээнд нийт 43 иргэн хамрагдаж, товллын дагуу дархлаажуулалтыг 0-2 насны дөрвөн багийн нийт 25 хүүхдийг 100 хувь хамрууллаа.

Коронавирусээс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг 4 удаагийн татан авалт хийж 18 наснаас дээш нийт 926 хүнийг вакцины нэгдүгээр тунд, 81 хүнийг хоёрдугаар тунд бүрэн хамрууллаа. Халдвараас сэргийлэх хяналтын багийн гишүүд эмнэлэгийн эмч ажилчдыг гар угааж, халдваргүйжүүлэх аргаар 3 удаа, хамгаалах хувцас хэрэгсэл өмсөх, тайлах аргаар 4 удаа нийт 7 удаа үнэлгээ хийсэн.

Хүлээн авах яаралтай тусламжаар нийт 26 хүнд, алсын дуудлагаар 6 том хүн, 2 хүүхдэд тусламж үйлчилгээг шуурхай, цаг алдалгүй үзүүлсэн. Өдрийн эмчилгээнд 2 хүн, больницоор 25 хүн нийт 27 хүн эмчлүүлээ. Сэргээн засах эмчилгээнд 12 хүн, уламжлалт эмчилгээнд 11 хүн нийт 23 хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн. Шинээр хяналтанд орсон 2 жирэмсэн эхэд товлот үзлэг шинжилгээнд хамруулж өөрчлөлттэй гарсан жирэмсэн эхийг тухай бүр нь эмчилгээ хийлээ.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотой “Коронавируст халдвар /covid-19/-ын үед иргэнийг тусгаарлах, ажиглах түр журам”-ын дагуу УБ хот, Ховд аймгаас ирсэн 46 иргэнийг хяналтанд авч өдөрт 3 удаа халууныг асууж зөвлөгөө өгч ажиллав. Баян-Өлгий аймгийн Булган сумын нутагт отроор хаваржиж буй Борт, Алаг, Хаг багийн айлуудын эргэлтээр Алаг багийн бага эмч ажиллав.

Мөнххайрхан Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанаас бүсийн сумдын Байгаль орчны тасаг, экоклубын сурагчидтай хамтран орчны бүсийн сумдын төв дайран өнгөрдөг Булган, Үенч, Сэнхэрийн голуудын ай сав дагуух хог цэвэрлэх ажлыг 2021 оны 5 дугаар сарны 15-20-ны өдрүүдэд зохион байгууллаа. Ховд аймгийн Булган сумын нутаг Шар булаг, Сухайт, Ярант чиглэлд хяналт шалгалт хийх явцад Булган голд хууль бусаар загас барих зорилгоор тор тавьсан зөрчил илэрч татсан торуудыг хураан авч, эзэн холбогдогчийг нь тогтоохоор ажиллаж байна.

Хамгаалалтын захиргаанаас хорио цээрийн дэглэмтэй энэ үед Алтайн хойлог, монгол хадран загасны судалгааны ажлын талаархи шторк бэлтгэж, сургалт, мэдээллийг цахимаар сурталчилж байна. ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн Цэвдэг судлалын салбарын хамт олон Швейцарын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр, өндөр уулын уур амьсгал, цэвдэг, мөстлөгийн өөрчлөлт тандан судлах цаг уурын иж бүрэн автомат станцын мэдээг хуулан авч холбогдох газарт хүргүүлэв. Баян-Өлгий аймгийн Булган сумын хэсгийг хариуцсан хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагч модны үрсэлгээ бэлтгэж, нутгийн иргэдтэй хамтран Сөнхөл нуур хэмээх газар 100ш бургас мод тарьж ногоон байгууламжийн тоог нэмэгдүүлэв.

Сумын цаг уурын ажилтан тайлант сард цаг агаарын мэдээг 248 удаа, агро мэдээг 3 удаа, Усны мэдээг 60 удаа төвд дамжуулж, төвөөс ирсэн хоногийн мэдээг 20 удаа, тав хоногийн мэдээг 5 удаа, долоон хоногийн төлөв мэдээг 5 удаа, сэрэмжлүүлэг мэдээг 1 удаа анхааруулга мэдээг 3 удаа, сарын мэдээг 1 удаа хүлээн авч сумын удирдлагуудад тухай бүр танилцуулж ажиллав.

Дөргөн сум: Сумын Засаг даргын 2021 оны А/39 дугаар захирамж, Сумын онцгой комиссын 04 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэрээр Ховд аймгийн төвөөс 2021 оны 04 сарын 26-ны өдөр 161 иргэнийг татан авч, 10 хоногийн хугацаанд гэрийн ажиглалтаар төрийн албан хаагчид хяналт тавьж ажиллав.

Коронавирус халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хэрэгжилтийг хангах зорилгоор сумын хэмжээнд Цагаан хаалга, Далантай баруун, Далантай зүүн, Шандас 4 цэгт хяналтын пост ажиллуулж, сумаас орох гарах иргэдийн хөдөлгөөнд хяналт тавин ажиллаж байна.

Сумын Засаг дарга, Аргалант багийн Засаг дарга, Багийн эмч нар 2021 оны 05 сарын 18,19-ны өдрүүдэд багийн малчин өрхүүдээр эргэлт хийж, хаваржилтын нөхцөл байдалтай танилцаж, ОНХС-ийн хөрөнгөөр сум болон багт хийх ажлын санал авч, аймаг орон нутгийн бодлого шийдвэр, хууль тогтоомжийн талаар мэдээлэл өгч, эрүүл мэндийн үйлчилгээг газар дээр нь үзүүлж ажиллалаа.

Худалдаа үйлчилгээний цэгүүдийн ажиллах цагийн хуваарийг өглөөний 09 цагаас оройн 20 цаг хүртэл, Банк тооцооны төвүүдийн үйл ажиллагааг 09-15 цаг хүртэл ажиллуулахаар сумын Засаг даргын захирамжаар хязгаарлалт тогтоосон.

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаан 05 дугаар сарын 19-ны өдөр хуралдаж ИТХ-ын стратеги төлөвлөгөө, Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны тайлан, Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцэн баталж тогтоол, шийдвэрүүдийг гаргалаа.

Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн e-mongolia.mn системээр тайлант сард цахимаар 9 албан бичиг хүлээн авч холбогдох албан тушаалтанд дамжуулаад байна.

Татварын ажилтан 05 дугаар сарын 10-ны дотор НӨАТ-ын тайлан гаргадаг 5 аж ахуй нэгжээс тайланг хугацаанд нь хүлээн авч, 2020 оны Хувь хүний орлогын албан татварын тайлангаар 25 иргэний 969630 төгрөгийн ногдол татварыг сумын төсөвт төвлөрүүллээ.

Нийгмийн даатгалын ажилтан Тэтгэврийн даатгалын сангаас нийт 398 тэтгэвэр авагчдад 139973,4 мянган төгрөгийн тэтгэвэр бүрэн олгосон. Үүнд: Өндөр насны тэтгэвэр авагч 305, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 30, тахир дутуугийн тэтгэвэр авагч 63 иргэнд олгов. Сайн дурын даатгалд нийт 83 даатгуулагчийн 5404,1 мянган төгрөг төсвийн байгууллага, аж ахуйн нэгжүүдээс 60117,7 мян төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, 2 даатгуулагчтай сайн дурын даатгалын гэрээ байгуулав. Эрүүл мэндийн даатгалд 19 даатгуулагчийн 1083,6 мянган төгрөгийн орлого оруулж Тэтгэмжийн сангаас жирэмсэн амаржсаны тэтгэмжид 4 даатгуулагчдад 6057,6 мян төг, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжид 2 иргэнд 97,2 мян төг, оршуулгын тэтгэмж 1 иргэнд 1000,0 сая төг тус тус олголоо.

Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр-37 хүнд 10.7, Ахмад настаны асаргаа 57 хүнд 4.6, ХБИ-ний асаргаа 19 хүнд 1.6, Тэжээгчээ алдсаны тэтгэмж 12 хүнд 3.5, Өрх толгойлсон 0-18 насны хүүхэдтэй эцэг эхэд олгох тэтгэмж 5 хүнд 2.1, Цалинтай ээж 161 эхэд 8.0, Жирэмсэн эхийн тэтгэмж 42 эхэд 1.7, Алдарт эхийн одон 4 хүнд 400 мянга, Хүүхдийн мөнгө 1240 хүүхдэд 12.4, Хүнсний эрхийн бичиг 33 өрх 2.8 нийт 32.9 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмжийг олголоо.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигын дагуу 2021 оны 05 сарын 10-ны өдөр “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг зохион байгуулах өдрийн хүрээнд Байгаль орчин аялал зуучлалын газраас 100 ширхэг мод авч “Хашаандаа мод тарья” гэсэн уриан дор ААН, албан байгууллага, ард иргэдтэй

хамтран мод тарьлаа. Сумын төвийн гудамж талбай болон нуурын хог хаягдлыг цэвэрлэх зорилгоор 05 сарын 15-16-ны өдрүүдэд бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгууллаа.

Тайлант сард малын халдварт болон гоц халдварт өвчин гараагүй. 2021 оны 05 дугаар сард Шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 21000 ишиг хамруулах төлөвлөгөөтэйгээс 20992 ишиг буюу 99 хувийн биелэлттэй хамруулж гүйцэтгэлийг мал эмнэлгийн нэгдсэн бүртгэлийн системд оруулсан. 300 үхэр, 1000 ямаа Цусан халдвар өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуултанд хамрагдсан. ДДХ, Сохор догол, сахуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт хийгдэж байна. Шүлхий өвчний тандалтанд 3 өрхийн 20 ямаа 20 хонь 8 үхэр нийт 48 малаас аймгийн лаборатори луу дээж авч илгээв.

Түүхий эд бүтээгдэхүүний мэдээгээр амьд мал 35 толгой, мах махан бүтээгдэхүүн 8,3 тн, ноолуур 2140 кг ширхэг тус тус мал эмнэлгийн гэрчилгээг олгож ажиллалаа.

Том малын зүй бус хорогдол өссөн дүнгээр адуу 15, үхэр 24, хонь 310, ямаа 445 нийт 794 толгой мал хорогдсон. Үүнээс Агваш 239, Сээр 210, Аргалант 265, Өгөөмөр 50 мал тус тус хорогдоод байна. Төл бойжилт сумын хэмжээнд ботго 696, унага 1028, хурга 12921, ишиг 40817, тугал 1176 нийт 56638 төл бойжсон Төлийн хорогдлын мэдээгээр тугал 9, унага 3, хурга 78 ишиг 145 нийт 235 төл хорогдсон мэдээтэй байна.

Долоо хоног бүрийн 1, 3 дахь өдрүүдэд хүнсний нөөцийн мэдээ, 7 хоног бүрийн 3 дахь өдөр том мал хорогдолт, төл бойжилтын мэдээнүүдийг гаргаж нэгтгэн аймгийн ХХАА-н газар хүргүүлэн ажиллаж байна.

Цар тахлын үед өндөржүүлсэн бэлэн байдлыг зарлаж, зорчигч тээврийн хөдөлгөөнийг хязгаарласан үед хүнсний нөөцийг бүрдүүлэх, татан авалт зохион байгуулах чиглэлээр аймгийн ХХААГ-аас зохион байгуулсан өгөгдсөн үүрэг чиглэлийн дагуу хүнсний худалдаа эрхлэгч нараас захиалгыг авч, аймгаас хүнс татан авалтын ажлыг 7 хоног бүрийн 2 дахь өдрүүдэд нийт 3 удаа зохион байгуулсан.

Хүнсний түүхий эд, бараа бүтээгдэхүүний түгээлт үйлчилгээнд тавигдах шаардлага, худалдааны ажиллагаанд тавигдах тусгай шаардлага журам зөвлөмжүүдийг үйлчилгээ явуулж буй аж ахуйн нэгжүүдэд танилцуулан хүргүүлж, Архи согтууруулах ундаа худалдаалахыг хориглосон сумын Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

Орон нутгийн сангаас малжуулах зээлийг 2017-2018 онуудад авсан малчдад мэдэгдэх хуудас хүргүүлж, зээл төлүүлэх арга хэмжээг авч нийт 15 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлж ажиллав.

Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлдэгч нарт зээл төлөлтөө хийх шаардлага тавьж 13 сая төгрөгийн орлогыг сум хөгжүүлэх сангийн дансанд төвлөрүүллээ.

Сумын Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг цаг алдалгүй шуурхай хүргэн ажиллаж байна. Амбулатороор 1226 хүн үйлчлүүлсэн. Нийт дуудлага 32 том хүний дуудлага 29, хүүхдийн дуудлага 3, Хэвтэн эмчлүүлсэн 16 үүнээс хүүхэд 1, том хүн 15 байна.

Гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээнд- 20 хүн, Сэргээн засах эмчилгээнд 10 хүн, Оношилгоо шинжилгээнд 28 хүн Өдрийн эмчилгээнд 7 хүн хамруулан эмчилгээ сувилгааг стандартын дагуу хийж байна

Эх хүүхдийн ноцтой хүндрэл гарахаас урьдчилан сэргийлж эхийг цаг тухайд нь хяналтандаа хамруулан ажиллаж байна. Энэ сард БОЭТ- 6 эх төрсөн. Шинээр 4 эхийг хяналтанд авч, нийтдээ 32 эхийг хяналтанд авч ажиллаж байна. Төрсөн эх нярайг 7 хоногт 1 удаа эргэлт хийдэг.

Зорилтот бүлгийн 30-60 насны эмэгтэйчүүдийн эрт илрүүлэгийн шинжилгээнд 1 эмэгтэй, 20-60 насны эмэгтэйчүүдийн эрт илрүүлэгийн шинжилгээнд 24 хүн хамруулсан хүнийг оношилгоо, шинжилгээнд хамрууллаа.

Товлолын вакцинд 33 хүүхэд хамрагдсан, Корона вирусын эсрэг нэмэлт дархлаажуулалтанд нийт 1205 хүн хамрагдсан. Үүнээс 162 хүн 2-р тунгаа хийлгэсэн байна.

Коронавирус өвчний талаарх мэдээллийг “Дөргөн ЭМТ” цахим хуудсаар нийт 140 төрлийн мэдээлэл зөвлөмжүүдийг ард иргэдэд өгч давхардсан тоогоор 1675 хүнд хүргэж ажилласан. ОУ-ын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 6-7нас, 8-10 насны хүүхдийн дунд “Корона вирусаас сэргийлье” сэдэвт гар зургийн уралдааныг зохион байгуулж байна.

Монгол улсад Covid 19 халдварт өвчний халдвар хүн амын дунд бүртгэгдсэнтэй холбогдуулан гаргасан Улсын Онцгой Комиссын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 34 дүгээр хурлын тэмдэглэл, Монгол Улсын Засгийн Газрын тогтоолууд, Аймгийн Засаг даргын захирамжууд, аймгийн онцгой комиссын

хуралдааны тогтоолууд, Эрүүл мэндийн газрын даргын тушаал, батлагдсан хуваарийн дагуу 2021 оны 4 дүгээр сарын 12-ний өглөө 08 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 18-ний 09 цаг хүртэл Мянгад сумын хяналтын постонд Дөргөн сумын эрүүл мэндийн төвийн баг үүрэг гүйцэтгэж ажиллав.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР